

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

ХӨДӨЛМӨРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА, ЦАЛИН ХӨЛСНИЙ ХЭЛТСИЙН
ТӨРИЙН АЛБАНЫ АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ, ЦАЛИН ХӨЛС, НИЙГМИЙН БАТАЛГААНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ
О.МЯГМАРСҮРЭНГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		Эхэлсэн, дууссан хугацаа
1	2	3	4	5	6	7	

Зорилт 1. Төрийн албаны ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тогтоомжийн төсөл боловсруулна.

1.	Арга хэмжээ 1.1. Төрийн албаны ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулна.	Тогтоолын төсөл боловсруулалтын гүйцэтгэлийн хувь	100%	100%	<ul style="list-style-type: none"> - Засгийн газрын 2022 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 487 дугаар тогтоолд Засгийн газрын 2025 оны 38 дугаар тогтооолоор нэмэлт оруулсан. - Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, цалин хөлсний талаарх судалгаа, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газар /Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан Төрийн албаны реформ хийх асуудлыг судалж, санал дүгнэлт боловсруулах Ажлын хэсэг/-т хүргүүлсэн. - 	2025.01.02-2025.06.10	100%
----	--	---	------	------	---	-----------------------	------

Зорилт 2. Төрийн албан хаагчийн цалин хөлсийг нэмэгдүүлэх талаар хууль тогтоомжийн төсөл боловсруулна.

2.	Арга хэмжээ 2.1. Төрийн албан хаагчийн цалин	Тогтоолын төсөл боловсруулалтын	100%	100%	- Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 161 дүгээр тогтоолыг хавсралтаар “Зэвсэгт хүчин,	2025.01.02-2025.06.10	100%
----	--	---------------------------------	------	------	---	-----------------------	------

	<p>хөлсийг инфляцийн түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх талаарх Засгийн газрын тогтоолын төсөл боловруулна.</p>	<p>гүйцэтгэлийн хувь</p>	<p>хил хамгаалах байгууллагын алба хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам"-ыг батлуулсан.</p> <p>Тогтоолын төсөл батлагдсанаар батлан хамгаалах, зэвсэгт хүчин, хил хамгаалах байгууллагын офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчийн цэргийн мэргэшлийн зэргийн нэмэгдлийг 5 хувиар нэмэгдүүлэн I зэрэгт 20 хувь, II зэрэгт 15 хувь, III зэрэгт 10 хувиар шинэчлэн олгох бөгөөд уг нэмэгдлийг олгоход 2.3 тэрбум төгрөг зарцуулна.</p> <ul style="list-style-type: none"> - Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн "Журам батлах тухай" 266 дугаар тогтоолоор "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгох журам"-ыг батлуулсан. <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын офицер, ахлагчид мэргэшлийн зэргийн нэмэгдлийг цэргийн байгууллагуудын мөрдэж байгаа хувь хэмжээтэй адилтган мэргэшлийн III зэрэгт 10, II зэрэгт 15, I зэрэгт 20 хувиар тооцож, албан тушаалын үндсэн цалингаас сар бүр бодож олгохоор зохицуулсан.</p> <p>Ингэснээр алба хаагчид өөрийгөө тал бүрээр хөгжүүлэх идэвх, санаачилга нэмэгдэх, бие бялдрын бэлтгэлжилт, мэдлэг боловсрол дээшлэх чухал ач холбогдолтой юм.</p> <p>Тогтоолыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрднө.</p> <ul style="list-style-type: none"> - Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн "Журам батлах тухай" 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. <p>-</p>	
--	--	--------------------------	--	--

Зорилт 3. Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах талаар хууль тогтоомжийн төсөл боловсруулна.									
3	<p>Арга хэмжээ 3.1. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгаа /тусламж, тэтгэмж, урамшуулал/ хангах талаарх Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулна.</p>	<p>Тогтоолын төсөл боловсруулалтын гүйцэтгэлийн хувь</p>	100%	100%	<ul style="list-style-type: none"> - Боловсролын сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, сангийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн "Шалгуур үзүүлэлт батлах тухай" А/136, А/80, А/69 дүгээр хамтарсан тушаалаар "Насан туршийн суралцахуйн төвийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт"-ийг батлуулсан. - Салбарын албан хаагчдын цалин хөлсний талаарх танилцуулга, мэдээлэл, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулан Төрийн нарийн бичгийн даргад танилцуулсан. Сангийн яамнаас цалингийн тодруулга авч, сайжруулалт хийн ажлын хэсгийн хурлыг зохион байгуулахаар ажиллаж байна. <p>Энэ хүрээнд Засгийн газрын "Журам батлах тухай" Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"- нэмэлт оруулах, 8 дугаар хавсралтаар баталсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа төрийн зарим албан хаагчид хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл олгох журам"-ыг шинэчлэн батлах Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан, Засгийн газрын гишүүдээс санал авахад бэлэн болгоод байна.</p> <ul style="list-style-type: none"> - Төрийн албандаа тогтвортой суурьшилтай ажиллаж байгаа төрийн албан хаагчид таван жил тутамд олгох урамшуулал болон төрийн албан хаагчид олгох орон нутгийн нэмэгдлийн талаар холбогдох танилцуулга, мэдээлэл, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газар /Монгол Улсын 	2025.01.02-2025.06.10	100%		

Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан Төрийн албаны реформ хийх асуудлыг судалж, санал дүгнэлт боловсруулах Ажлын хэсэг/-т хүргүүлсэн.

- Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн Боловсролын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал хүргүүлсэн.

- Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал боловсруулан хүргүүлсэн.

- Боловсролын яамнаас ирүүлсэн “Журам батлах тухай” Засгийн газрын 2024 оны 25 дугаар тогтоол болон тогтоолын хавсралтаар батлагдсан “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”-д өөрчлөлт оруулах Засгийн газрын тогтоолын төсөлд санал боловсруулан хүргүүлсэн.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн “Цэргийн дээд офицер цолны нэмэгдэл олгох тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд санал боловсруулан хүргүүлсэн.

- Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн “Төрийн тусгай зарим албан тушаалыг төрийн захирагааны албан тушаалын ангилалд адилтган авч үзэх албан тушаалын жагсаалтын тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд санал боловсруулан хүргүүлсэн.

- Соёлын яамнаас ирүүлсэн “Журам батлах тухай” (Орон нутгийн биеийн тамир, спортын байгууллагын ажилтан, арга зүйч,

				дасгалжуулагчид мөнгөн тэтгэмж олгох журам) Засгийн газрын тогтоолын төсөлд санал боловсруулан хүргүүлсэн.		
Зорилт 4. Төрийн албан хаагчдыг зайнаас цахимаар, цагаар ажиллуулах эрх зүйн актын төсөл боловсруулна.						
	Арга хэмжээ 4.1. Төрийн албан хаагчдыг зайнаас цахимаар, цагаар ажиллуулах журмын төсөл боловсруулна.			Засгийн газрын 2024 оны 11 сарын 13-ны өдрийн “Хуулийн биелэлтийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 164 дүгээр тогтоол батлагдсан. Төрийн албаны тухай хууль болон дээрх тогтоолын хүрээнд “Төрийн албан хаагчдын зайнаас, цахимаар, цагаар ажиллах журам” НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран 06-10 дугаар сард боловсруулахаар төлөвлөөд байна.	2025.01.02-2025.06.10	100%

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Төрийн албан хаагчийн нийгмийн баталгаатай холбоотой шинээр гарсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн тухай төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж байгууллагын холбогдох албан тушаалтнуудад чиглэл, зөвлөмж мэдээлэл өгөх.	Хуульд нийцсэн үндэслэл бүхий үнэн зөв мэдээлэл, чиглэл, зөвлөгөө	100%	100%	1. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ ТӨРИЙН АЛБАНЫ МАНЛАЙЛАЛ” бүсийн чуулганы бүх бүсэд “Төрийн албан хаагчийн хөдөлмөрлөх эрх, нийгмийн баталгааны хэрэгжилт” сэдвээр илтгэл мэдээлэл боловсруулан танилцуулав. 2. Улсын Их Хурлын Даргын 2024 оны 98 дугаар захирамжаар байгуулсан Ажлын хэсгийн ахлагч Д.Ганмаагийн 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан “Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангамж, ажлын ачаалал, бүтээмж, ажлын гүйцэтгэл, үр дүнтэй уялдсан цалин хөлс, урамшуул олгоход тулгарч буй асуудал” сэдэвт хэлэлцүүлэгт оролцож, “Төрийн албан хаагчийн цалин хөлс” сэдвээр танилцуулга, мэдээлэл боловсруулан танилцуулав. 3. Төрийн албан хаагчийн ангилал, зэрэглэл, цалин хөлс, нийгмийн баталгаатай холбоотой УИХ, Засгийн газрын шийдвэртэй холбоотой	2025.01.02-2025.06.10	100%

					<p>мэдээлэл, зөвлөмж авахыг хүссэн иргэд, байгууллагыг мэдээлэл, арга зүйгээр хангаж ажиллав.</p> <p>Энэ хугацаанд:</p> <ul style="list-style-type: none"> - 75 албан бичиг ирсэн бөгөөд хариутай бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, зохих хариуг хүргүүлсэн. - Иргэдээс гаргасан 17 өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж, хариуг өгсөн. - Мөн иргэд, байгууллагуудаас мэдээлэл зөвлөгөө авахаар утсаар холбогдсон тухай бүр хариу өгч ажилласан. 		
2.	Үүрэг даалгавар (Арга хэмжээ) 2. Хууль тогоомжийн хэрэгжилт, Монгол Улсыг хөгжүүлэх бодлогын баримт бичиг болон бусад холбогдох баримт бичгүүдэд тусгагдсан арга хэмжээний биелэлт, явцын талаарх мэдээллийг хуулийн хугацаанд багтаан яамны холбогдох газар, хэлтэст гаргаж өгөх.	Хууль тогоомжийн хэрэгжилт, Монгол Улсыг хөгжүүлэх бодлогын баримт бичгийн биелэлт, хэрэгжилтийн талаар мэдээлэл	100%	100%	<p>Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө Үндсэн чиглэл/, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг сар бүр, Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийг хуулийн хугацаанд нь тус тус гарган Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлсэн.</p>	2025.01.02- 2025.06.10	100%
3.	Үүрэг даалгавар (Арга хэмжээ) 3. Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг				<p>1. Нийгмийн хамгааллын үндэсний тогтолцооны загвар боловсруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан.</p> <p>Залуу судлаачдыг дэмжих сан ТББ-тай хамтран гүйцэтгэсэн судалгааны хүрээнд Монгол Улсын</p>		100%

	биелүүлэх				<p>нийгмийн хамгааллын тогтолцоо, салбарын үйл ажиллагааг зохицуулж байгаа 100 орчим эрхзүйн актад нэг бүрчлэн шинжилгээ хийж, системийн инженерчлэлийн аргаар үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид хэрэгжүүлэх бодлогын зөвлөмжийг 5 чиглэлээр гарган ажилласан.</p> <p>2. Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 02 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж, 2025 оны 02 дугаар сарын 10-21-ний өдрүүдэд Сэлэнгэ аймгийн 17 сум, 6 тосгон, Төв аймгийн Борнуур, Сэргэлэн, Зуунмод сумдад ажилласан.</p> <p>Төрийн албаны зөвлөлийн гишүүн бөгөөд Ёс зүйн хорооны дарга Ц.Амартөгс ахалсан уг ажлын хэсэг суманд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагууд төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж буй байдал, хүний нөөцийн зохицуулалтын хэрэгжилтэд хяналт шалгалт хийлээ. Мөн төрийн албан хаагчдад төрийн албаны шинэтгэлийн үйл явц, төрийн албан хаагчийн цалин хөлсний шинэтгэлийн талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний хэрэгжилт, төрийн албаны “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системийн шинэ хөгжүүлэлтүүд, түүнийг хэрхэн ашиглах, Ёс зүйн дэд хороо хэрхэн ажиллах талаар зөвлөгөө, зааварчилгаа өгсөн.</p>	
--	-----------	--	--	--	---	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		Эхэлсэн, дууссан хугацаа
1	2	3	4	5	6	7	

1.	Арга хэмжээ 1. Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах.	Сертификат, гэрчилгээ	Ахлах түшмэлийн мэргэшүүл эх багц сургалтад хамрагдсан	100%	Яамны "Мэдээллийн цаг"-аар зохион байгуулсан сургалтуудад тухай бүр хамрагдсан. Тухайлбал, - Б.Мянганы (Ph.D) "Soft skill ба Бидний ажлын үр дүн"; - "Хан-Уул" Эрүүл Мэндийн Төвийн дарга, Анаагаах Ухааны Доктор Н.Наранбаатарын "Хүүхдийг хүмүүжүүлэх боломжгүй – Харин эцэг эхчүүд насанд хүрнэ л гэж байдаг"; - Олон улсын хэмжээний ICF сертификаттай Көүч, мэргэжлийн Art Therapist багш, сэтгэл засалч Ч.Энхжаргал "Байгууллагын стресс менежмент, хувь хүний мотивацижуулалт"; - Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Эрдэнэбатын "Хиймэл оюун ухаан-Хөдөлмерийн шилжилт"; - Хувь хүний хөгжлийн институтын захирал, сэтгэл зүйч М.Алтанцэцэгмийн "Цагийн менежмент"; - Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлийн Цахим сэтгүүл зүй хариуцсан дэд ерөнхийлөгч Ц.Мөнхбаатарын "Rhetoric буюу илтгэх урлаг" сэдэвт сургалтуудад хамрагдас.	2025.01.02-2025.06.10	100%
----	---	-----------------------	--	------	--	-----------------------	------


ТАЙЛАН ГАРГАСАН:

ХБГ-ЫН ХХЦХХ-ИЙН ШИНЖЭЭЧ

(Албан тушаал)

 /О.Мягмарсүрэн/

(Нэр, гарын үсэг)

 /Огноо/

(Огноо)

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
8 дугаар хавсралт

**ХӨДӨЛМӨРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН
ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА, ЦАЛИН ХӨЛСНИЙ ХЭЛТСИЙН
ТӨРИЙН АЛБАНЫ АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ, ЦАЛИН ХӨЛС, НИЙГМИЙН
БАТАЛГААНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ
О.МЯГМАСҮРЭНГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН
ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС
(ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)**

Байгууллагын нэр: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Нэгжийн нэр: Хөдөлмөрийн бодлогын газрын Хөдөлмөрийн харилцаа, цалин хөлсний хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/ Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуул ж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	

Зорилт 1. “Төрийн албаны ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тогтоомжийн төсөл боловсруулна.”-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт

1.	Арга хэмжээ 1.1. Төрийн албаны ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулна.	60	10	70	70
----	--	----	----	----	----

Зорилт 2. “Төрийн албан хаагчийн цалин хөлсийг нэмэгдүүлэх талаар хууль тогтоомжийн төсөл боловсруулна.”-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт

1.	Арга хэмжээ 2.1. Төрийн албан хаагчийн цалин хөлсийг инфляцийн түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх талаарх Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулна.	60	10	70	70
----	---	----	----	----	----

Зорилт 3. “Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах талаар хууль тогтоомжийн төсөл боловсруулна.”-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт

1.	Арга хэмжээ 3.1. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах талаарх Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулна.	60	10	70	70
----	---	----	----	----	----

Зорилт 4. Т Төрийн албан хаагчдыг зайнаас цахимаар, цагаар ажиллуулах эрх

ЗҮЙН АКТЫН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛНА.					
1.	Арга хэмжээ 4.1. Төрийн албан хаагчдыг зайнлас цахимаар, цагаар ажиллуулах журмын төсөл боловсруулна.	60	10	40	70
Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт					
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Төрийн албан хаагчийн нийгмийн баталгаатай холбоотой шинээр гарсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн тухай төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж байгууллагын холбогдох албан тушаалтнуудад чиглэл, зөвлөмж мэдээлэл өгөх.	60	10	40	70
2.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Хууль тогтоомжийн хэрэгжилт, Монгол Улсыг хөгжүүлэх бодлогын баримт бичиг болон бусад холбогдох баримт бичгүүдэд тусгагдсан арга хэмжээний биелэлт, явцын талаарх мэдээллийг хуулийн хугацаанд багтаан яамны холбогдох газар, хэлтэст гаргаж өгөх.	60	10	40	70
3.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх	60	10	40	70
Дундаж оноо:					

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт					
Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо	
				1	2
1.	Арга хэмжээ 1. Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах.	90	13,5	13,5	13,5
Дундаж оноо					

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)					
Д/Д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо		
			1	2	3

1.	Хандлага, ёс зүй	7	
2.	Дүн шинжилгээ хийх	7	
3.	Асуудал шийдвэрлэх	7	
4.	Хариуцлагатай байдал	7	
5.	Ажлын цаг ашиглалт	7	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6.	Мэргэжлийн ур чадвар 1.		
7.	Мэргэжлийн ур чадвар 2.		
8.	Мэргэжлийн ур чадвар 3.		
Дундаж оноо		7	7

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	8
3.	Харилцаа	8
Дундаж оноо		8

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бурийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	(70 хүртэлх оноо) 70
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	(15 хүртэлх оноо) 15
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	(7 хүртэлх оноо) 7
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	(8 хүртэлх оноо) 8
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	(..... оноо)
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		98,5

Үнэлгээ өгсөн:

ХБГ-ын ХХЦХХ-ийн дарга
(албан тушаал)

Нэгжийн дарга

.....
(гарын үсэг)

/Б.Нарангарав/
(албан хаагчийн нэр)

2023.06.10.
(огноо)

Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:

ХБГ-ын шинжээч
(албан тушаал)

.....
(гарын үсэг)


/О.Мягмарсүрэн/
(албан хаагчийн нэр)

2023.06.10. (огноо)

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

ТЗУГ-ЫН ДАРГА
(албан тушаал)


/B.Tүвшинжаргал/
(албан хаагчийн нэр)

2025.06.20
(огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

ТЗУГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН
(албан тушаал)



/Б.Баянжаргал/
(албан хаагчийн нэр)

2025.06.20
(огноо)

Үнэлгээг баталгаажуулсан: Төсвийн шууд захирагч

Төрийн нарийн бичгийн дарга
(албан тушаал)




/Л.Мөнхзул/
(албан хаагчийн нэр)

2025.06.20
(огноо)